



ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,  
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,  
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

Төлбөрт үйлчилгээний тарифын тухай

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Зохицуулах хорооны дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.7 заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хэрэглэгчдээс ирсэн дуудлагыг түргэн шуурхай шийдвэрлэх, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор хэрэглэгчийн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалт, засварын төлбөрт үйлчилгээний тарифыг техник, технологийн найдвартай ажиллагааны шаардлагад нийцүүлэн хамгийн бага өртгийн зарчмыг мөрдөн тогтоохыг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

2. Хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэн, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээний чанарт хяналт тавьж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

4. Энэхүү тогтоолыг эс зөвшөөрвөл Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Д.АНХБАТ

Ц.БАТЗАЯА

Т.УЛАМБАЯР

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН  
АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Бүртгэлийн дугаар: .....119.....

**ХУУЛБАР ҮНЭН**

.....*Г. Цогтсайхан*.....*арг*  
(Албан тушаалын нэр)

(гарын үсэг) (гарын үсгийн тийлэл)

2024.06.19 147410202